



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 02 дугаар сарын 02 өдөр Дугаар 13

Хэрлэн сум



ХИИ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 13 дугаар хуралдаан 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 14:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 84,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

- 1.Ном айлтгал хийх зан үйлийг цахимаар зохион байгуулах талаар хэлэлцэх,  
*Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар*
- 2.Буйр нууранд осолдсон 2 тээврийн хэрэгслийг татаж гаргах талаар хэлэлцэх,  
*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*
- 3.Аймгаас гарах, орох тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах, хянах үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар хэлэлцэх,  
*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар  
Цагдаагийн газар*
- 4.Зах худалдааны төвүүд, үйлдвэрлэл үйлчилгээний болон төрийн байгууллагууд, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудад коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөн туслах асуудлаар хэлэлцэх,  
*Мэргэжлийн хяналтын газар*
- 5.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх хугацааг сунгах эсэх талаар хэлэлцэх,  
*Цагдаагийн газар*
- 6.Аймгийн Онцгой комиссын шуурхай штаб, тохиолдлын удирдлагын тогтолцооны бүрэлдэхүүнийг томилох тухай хэлэлцэх,  
*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар  
Эрүүл мэндийн газар*
- 7.Хөлөнбуйр, Цагаан-Овоо сумын хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдын зардал танилцуулж шийдвэрлүүлэх,  
*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

/  / М.Бадамсүрэн  
/  / Э.Ганжигүүр

8.Хөлөнбуйр сумын хяналтын цэгийн ариун цэврийн байгууламжийн хэвийн ажиллагааг хангах зардлын тооцоог танилцуулж шийдвэрлүүлэх,  
*Аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

1.1.Сар шинийн баяраар уул овоонд гарах, айл хэсэх, гэртээ хүн урихгүй, бөөгнөрөл үүсгэхгүй байх чиглэлээр аймгийн Онцгой комиссын тогтоол гаргах бэлтгэл ажлыг хангаж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулахыг,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,  
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа нарт:

1.2.Цар тахлын үед ажиллах сүм, хийдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг зохион байгуулж дүгнэлтийг аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулахыг,

Хоёр.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

2.1.Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, Байгаль орчны улсын байцаагч, Цагдаагийн хэсгийн төлөөглөгч нарыг томилж Буйр нуурт газар дээр нь ажиллуулахыг,

2.2.Орчны нөхцөл байдлыг үнэлж тогтоох, буруутай этгээдээр зардлыг гаргуулахыг,

2.3.Буйр нууранд осолдсон 2 тээврийн хэрэгслийг татаж гаргах ажиллагааг аюулгүй байдлыг хангаж зохион байгуулахыг,

Гурав.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,  
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа нарт:

3.1.Зөвшөөрөгдсөн тээвэрлэлт хийж буй иргэд, аж, ахуйн нэгж байгууллагатай коронавируст халдвар /COVID-19/-ын эрсдлээс урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх, тусгаарлан ажиглалтын чиглэлээр хамтран ажиллах тухай гэрээ байгуулж ажиллахыг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын орлогч, Онцгой комиссын нарийн бичгийн дарга, дэд хурандаа Д.Баттулга-д:

3.2.Аймгийн Онцгой комиссоос гаргасан тогтоол, шийдвэрийг боловсруулж баталгаажуулахыг,

АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Баяржаргал-д:

*Ч.Оюунаа* /М.Бадамсүрэн  
*Ч.Ганбат* /Э.Ганжигүүр



3.3.Аймгийн Засаг даргаас гаргасан албан даалгавар, захирамжийг боловсруулж баталгаажуулахыг,

3.4.Иргэнээс ирсэн гомдлын дагуу Дотоод хяналтын ажлын хэсэгтэй хамтран зөрчил гаргасан хяналтын цэгт хяналт, шалгалтыг зохион байгуулж дүгнэлтийг аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулахыг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа нарт:

3.5.Шалган нэвтрүүлэх хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж буй албан хаагчдад өдөр бүр зааварчилгаа өгч ажиллахыг,

Дөрөв.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,

4.1.Коронавируст халдвар /COVID-19/-ын заавар, зөвлөмжийг мөрдөхгүй байгаа аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар зогсоож хуулийн дагуу арга хэмжээ авах, зөвлөн туслах ажлыг эрчимжүүлж авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тухай бүр аймгийн Онцгой комиссын хуралд танилцуулж байхыг,

Тав.АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Баяржаргал,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын орлогч, Онцгой комиссын нарийн бичгийн дарга, дэд хурандаа Д.Баттулга нарт:



5.1.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэхийг 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрөөс 02 дугаар сарын 16-ны өдрийг хүртэлх хугацаанд тодорхой хязгаарлалттайгаар зөвшөөрөх тухай аймгийн Онцгой комиссын тогтоол, аймгийн Засаг даргын захирамж батлуулахыг,

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дарга,  
Онцгой комиссын гишүүн Д.Должин-д:

5.2.Шүүхийн шийдвэрийн дагуу Цагдаагийн газрын саатуулах байранд тодорхой хугацаанд баривчлан саатуулагдах иргэдийг саатуулагдахаас өмнө PCR шинжилгээнд хамруулахыг,

Зургаа.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

6.1.Аймгийн Онцгой комиссын шуурхай штаб, тохиолдлын удирдлагын тогтолцооны багийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын захирамжаар томилгоожуулахыг,

 / М.Бадамсүрэн  
 / Э.Ганжигүүр

6.2.Бүлэг, багийн хурлыг зохион байгуулж үйл ажиллагааны чиг үүргийг өгч үүрэгжүүлэхийг,

Долоо.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

7.1.Хөлөнбуйр сум, Баянтүмэн, Ялалт, Модон гүүрийн хяналтын цэг, Гамшгаас хамгаалах Эрүүл мэндийн албаны штабын 2021 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс 03 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд шаардагдах үйл ажиллагааны зардлын тооцоог аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг,

7.2.Улаанбаатар хотоос ирсэн Хэрлэн сумын харьяатай иргэдэд зохион байгуулсан явуулын тандалтын давтан шинжилгээний багийн ажилласан үйл ажиллагааны зардлыг тооцож Хэрлэн сумын Онцгой комисст танилцуулж шийдвэрлүүлэхийг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

7.3.Цагаан-Овоо сумын Онцгой комиссоос аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийн дагуу хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдын зардлын тооцоог аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг,

Найм.АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа-д:

8.1.Хөлөнбуйр сумын хяналтын цэгийн ариун цэврийн байгууламжийн хэвийн ажиллагааг хангах зардлыг тооцоог аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН  
ДАРГА  М.БАДАМСҮРЭН

БҮСИЙН ТӨВ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ГАЗРЫН АХМАД  Э.ТАНЖИГҮҮР